Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Насан туршийн суралцахуйн салбар хоорондын хамтын ажиллагааны бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Гансүх Энх-Үрэл

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Иргэдийн Монгол хэл, бичгийн чадамжийг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 1 | Гадаад улсад амьдарч буй Монгол иргэдэд чиглэсэн арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтэд зөвлөн тусалж хамтран ажиллана. | Арга хэмжээ | - | Арга хэмжээг батлуулсан байна. | Монгол хэл, соёлыг хилийн чанадад түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын төлөөлөлд холбогдох мэдээллийг албан ёсоор танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны боломж, чиглэлийн талаар санал солилцсон. Үүнд: 1. Чикаго хот орчимд амьдарч буй монгол иргэдийн хүүхдүүдэд монгол хэл, соёлын өв уламжлалаа заан сургах, өвлүүлэх зорилгоор АНУ-ын Чикаго хот орчимд үйл ажиллагаа явуулж буй | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Монгол Мэдлэг” болон “Чикаго Монгол” нэртэй сургалтын төвөөс холбогдох танилцуулга, дэмжлэг хүссэн албан бичгийг ирүүлсэн. Ирүүлсэн хүсэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд судлан үзэж, журмын дагуу холбогдох хариуг албан ёсоор хүргүүлсэн. 2. Солонгос улсад амьдарч буй хүүхэд, залуус, гэр бүлүүдэд боловсрол болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг “HAMY-Солонгос дахь хүүхэд, гэр бүл сэтгэл зүйн төв”-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, тус төвийн үйл ажиллагааны явц, тулгамдаж буй асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замуудын талаар санал солилцсон. Уулзалтын үр дүнд талууд мэргэжлийн сэтгэл зүйч, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөхүүдийн оролцоотой сургалт, уулзалт зохион байгуулах, хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан монгол хэл, соёлын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим сурах бичиг, гарын авлагаар хангах тал дээр анхаарах зэрэг саналуудыг дэвшүүлэв. 3. Солонгос улсад үйл ажиллагаа явуулдаг “Монгол, Солонгос хэл бичиг, соёлын төв”-ийн хүсэлтийг холбогдох журмын хүрээнд судалж, Гадаад хамтын ажиллагааны газарт хариу бичиг боловсруулахад шаардлагатай санал, дэмжлэгийг хүргүүлсэн. Цаашид хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй Монголчуудын холбоод, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, дэмжлэгийг шат дараатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.<br>Хавсралт: 2 файл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. "Боловсролын чөлөөт бүс" арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | | | | | | | |
| 2 | "Боловсролын чөлөөт бүс" арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. | Хамтран ажилласан арга хэмжээ | - | Хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээллийг хугацаанд нь гаргасан байна. | “Боловсролын чөлөөт бүс” арга хэмжээний хүрээнд боловсролын чанарын ялгааг бууруулах, хилчид болон хил орчмын алслагдсан бүс нутгийн малчин иргэдийн хүүхдүүдэд гэрт ойр бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх зорилгоор багийн бага сургууль байгуулах санаачилгыг дэмжин, бичил номын сан байгуулах ажлын хэсгийн шаардлагатай мэдээлэлд санал өгч хамтран ажилласан. Мөн бага ангийн бүлгийн хэт ачааллыг бууруулах, бага насны хүүхдүүдийг гэртээ ойрхон, аюулгүй орчинд суралцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хотхоны бага сургууль байгуулах ажлын хүрээнд холбогдох мэдээллийг хугацаанд нь гаргаж өгч хамтран ажиллана.<br>Хавсралт: 2 файл | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.3. Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ. | | | | | | | |
| 3 | ESIS системийн хөгжүүлэлтэд эрхлэх асуудлын хүрээнд санал өгч, хамтран | Системийн хэрэгжилт | - | Санал өгч, хамтран ажилласан байна | Боловсролын удирдлага, мэдээллийн систем (ESIS)-ийн насан туршийн суралцахуйн төвийн | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллана. | | | | тайлангийн статистик маягтад тусгах саналыг боловсруулах хүрээнд Боловсролын ерөнхий газрын насан туршийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэн, З-БДБ-НТБ-1-Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын хичээлийн жилийн тайлан /нас, хүйс, боловсролын түвшин, ангиар/, З-БДБ-НТБ-1.1-Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын хичээлийн жилийн тайлан /сургалтын байгууллага, нас, хүйсээр/, З-БДБ-НТБ-2-Насан туршийн суралцахуйн төвд ажиллагчдын хичээлийн жилийн тайлан /нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг/, З-БДБ-НТБ-2.1- Насан туршийн суралцахуйн төвд ажиллагчдын хичээлийн жилийн тайлан /сургалтын байгууллага, нас, хүйс, боловсролын түвшин/ гэсэн дөрвөн төрлийн маягтын саналыг Боловсролын статистик мэдээллийн хэлтэст | сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлсэн. Мөн хувь хүний хөгжил, амьдрах ухааны сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдаж буй иргэдийн бүртгэл, холбогдох мэдээллийг илүү нарийвчлан тодорхойлох зорилгоор асуулга хэлбэрээр нэгтгэн авах санал дэвшүүлэн хамтран ажилласан. Хавсралт: 4 файл | | |
| 4 | Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэхэд санал өгч, хамтран ажиллана. | Систем хөгжүүлэх санал | - | Санал өгч, хамтран ажилласан байна. | Насан туршийн суралцахуйн төвүүдийнг зохион байгуулдаг хувь хүний хөгжил, амьдрах ухааны сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдаж буй иргэдийн бүртгэл, мэдээлэл нэгдсэн төв тус бүрт байгааг ESIS системд нэгтгэж авах санал өгсөн. Үүний хүрээнд боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтын зөвлөмж, хувь хүний хөгжил, амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг сайжруулан боловсруулах шаардлага гарсан. Боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтын зөвлөмж боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байгаа. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 2 файл | | |
| 5 | Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3, 17.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасан бодлогын баримт бичгийн төслийг батлуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | Бодлогын баримт бичгийн төсөлд өгөх санал | - | Шаардлагатай мэдээлэл цуглуулж санал өгч, хамтран ажилласан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3, 17.4 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт тусгагдсан бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хуралдах явцад хамтран ажилласан. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 6 | Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмын төсөл боловсруулахад санал өгч, хамтран ажиллана. | Журмын төсөл | - | Журмын төсөлд санал өгч, хамтран ажилласан байна. | Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 253/А/123 дугаар хамтарсан тушаалаар “Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах” журмыг баталсан. Журмыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэхээр ХЗДХЯ-д хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | 2-р сар, 3-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 7 | Урт болон богино хугацааны бодлогын | Хэрэгжилтийг хугацаанд нь | - | Бодлогын баримт бичигт тусгагдсан | Холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгсөн. | 1-р сар, 2-р сар, 3-р | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг тайлагнаж ажиллана. | тайлагнасан байх | | эрхлэх асуудалын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь чанартай тайлагнасан байна. | | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 8 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах аргачлалд заасан шаардлагыг бүрэн хангасан байх | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө | Төлөвлөгөөг тогтоосон хугацаанд батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна. | 2025 оны төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн. Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан, албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулсан. Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин |
|---|---|---|---|

| | хэрэгжүүлэх арга хэмжээ | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Байгууллагын мэдээллийн цагт хамрагдаж мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлнэ. | Хуваарийн дагуу хамрагдана. | 2 долоо хоногт 1 удаа хамрагддаг. | Хуваарийн дагуу тогтмол хамрагдсан байна. | Байгууллагын мэдээллийн цагт тогтмол хамрагдсанаар боловсрол, технологи, хууль эрх зүй, эдийн засаг, ёс зүй, үндэсний аюулгүй байдлын чиглэлээр мэдлэг, ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлсэн. Тухайлбал, Монголын боловсролын хувирган өөрчлөлт, шинэчлэл, хиймэл оюун ухааны хөгжил ба хэрэглээ, кибер гэмт хэргийн эрсдэл болон түүнийг зохицуулах хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, ажлын байран дахь ёс зүйтэй манлайллын зарчим, мөн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бодлого, арга хэмжээний талаар ойлголттой болсон.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | Цахим хичээлд хамрагдана. | Байгууллагаас зохион байгуулсан | Дунд шатны сургалтад хамрагдаж | Монгол Улсын Засгийн газрын 96 дугаар тогтоолоор баталсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалтад хамрагдсан. | сертификат авсан байна. | Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах цаашид монго бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх, бэлтгэх зорилготой "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулдаг "Үндэсний бичгийн дунд шатны сургалт"-д цахим хэлбэрээр хамрагдсан.<br>Хавсралт: 1 файл | сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ: 90% |
| 3 | Олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын чиг хандлагын талаарх гарч буй гарын авлага, зөвлөмжийг уншиж судлах | UNESCO, OECD зэрэг олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар гарч байгаа бодлогын зөвлөмж, гарын авлагыг уншиж судлах | - | Насан туршийн боловсролын чиглэлээр англи хэл дээр гарч байгаа олон улсын судалгааны ажил, өгүүллэгийг уншиж танилцана. | ЮНЕСКО-гийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээ (СХДС) нь 2013 онд байгуулагдсан бөгөөд 2025 оны байдлаар дэлхийн 356 хот гишүүнээр элссэн байна. Суралцагч хотуудын туршлага нь Монгол Улсад насан туршийн боловсролыг хөгжүүлэх, орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, боловсролын хүртээмжийг сайжруулахад чухал үлгэр дуурайлл болж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цаашид эдгээр туршлагыг нутагшуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна. Тиймээс Боловсролын сайдын 2025 оны 03 сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Суралцаг хот” сургалтыг 2025 онд зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийн 7 үйл ажиллагааны ажил гүйцэтгэх гэрээний төсөл боловсруулж, батлуулсан. Солонгос улсын Насанд хүрэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг судалсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4 | Эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомжийг судлах | Хууль тогтоомжийг судлах | - | Эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомжийг судалж сан үүсгэсэн байна. | Насан туршийн суралцахуйн төвүүдийн сургалтын хөтөлбөрүүд нь нийгмийн олон бүлгийн хэрэгцээнд нийцсэн, амьдралд ойр, хүртээмжтэй байдлаар хэрэгжиж байна. Цаашид эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна. Тиймээс Боловсролын сайдын 2025 | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/98 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих” арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийн 4-т Малчин залуучуудад боловсрол нөхөн олгох, бичиг үсгийн боловсрол олгох, хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах үйл ажиллагаа төлөвлөгдсөн ба бусад холбогдох 11 үйл ажиллагааны ажил гүйцэтгэх гэрээний төсөл боловсруулж, батлуулсан. Гэрээнд заасны дагуу үйл ажиллагаа хийгдэж байна. Хавсралт: 2 файл | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Насан туршийн суралцахуйн салбар хоорондын хамтын ажиллагааны бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Гансүх Энх-Үрэл /................................................../ Огноо: .........................